

**“Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Хараат бус гишүүн  
М.Батжаргалын 2023 оны эхний хагас жилийн ажлын тайлан**


Монгол Улсын Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон бусад холбогдох хууль, Монголбанкнаас баталсан “Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”, Төрийн банкны дүрмийн дагуу хараат бус гишүүний үүргээ гүйцэтгэн ажилласан. 2023 оны эхний хагас жилийн байдлаар Хувьцаа эзэмшигчдийн хуралд 1 удаа, Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд 8 удаа оролцож, хэлэлцсэн асуудлыг шийдвэрлэхэд өөрийн санал дүгнэлтээ өгч ажилласан.

Тайлант хугацаанд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн болно. Үүнд:

- Төрийн банкны Эрсдэлийн удирдлагын хорооны ажиллах журам, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын ажиллах журам, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын үйл ажиллагааны журам, Төрийн банкны мэдээллийн аюулгүй байдлын бодлого, Төрийн банкны сонирхлын зөрчлийг зохицуулах журам, Дотоод аудитын газрын дүрэм, чиг үүрэг, Байгаль орчин, нийгэм, засаглалын бодлого, Төрийн банкны захирлуудын зөвлөлийн үйл ажиллагааны журмын нэмэлт өөрчлөлттэй танилцан, шинэчлэн баталсан.
- “Төрийн банк ХК-ийн Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлого”, Хувьцаа эзэмшигч, олон нийтэд Төрийн банк ХК-ийн мэдээллийг ил тод мэдээллэх, тайлагнах журам, Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөр, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Засаглалын албаны үйл ажиллагааны журам, Тогтвортой хөгжлийн хорооны үйл ажиллагааны журам, Төрийн банк ХК олон нийтэд хувьцаа нэмж гаргахтай холбогдуулан зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдүүдийг сонгон шалгаруулах журам, Төрийн банк ХК-ийн Гүйцэтгэх захиралд нэр дэвшигчийг сонгон шалгаруулах журмын төсөлтэй танилцан баталсан.
- Төрийн банкны 2022 оны болон 2023 оны 1 дүгээр улирлын үйл ажиллагааны тайлан, 2023 оны 1 дүгээр улирлын худалдан авалтын үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлан, Гүйцэтгэх захирал Ө.Гантөрийн 2021 оны хөдөлмөрийн гэрээний биелэлт, үр дүн, Комплаенсийн газрын 2022 оны 4 дүгээр улирлын тайлан, Төрийн банкны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 1 дүгээр улирлын тайлан, Төрийн банк ХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн Грант Торинтон аудит ХХК-ийн аудитын дүгнэлттэй танилцан үүрэг даалгавар өгч ажилласан.
- Хувьцаа эзэмшигчдийн хуралд 1 удаа оролцон, хэлэлцсэн асуудлуудтай танилцсан.
- Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны хуралд 6 удаа, Нэр дэвшүүлэх хорооны хуралд 2 удаа, Цалин урамшууллын хорооны хуралд 1 удаа, Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны хамтарсан хуралд 1 удаа оролцсон. Төрийн банк ХК-ийн Цалин хөлсний журам, Хяналтын зөвлөлийн ажиллах журам, Дотоод аудитын газрын 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, 2023 оны санхүүгийн тайланд Хөндлөнгийн аудитын төсөлтэй танилцан баталсан.

Гүйцэтгэх захирлын хөдөлмөрийн гэрээний биелэлтийн, үр дүнгийн талаар хэлэлцэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.

- Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудал, шийдвэртэй зарчмын зөрүүтэй байр суурьтай байгаагүй бөгөөд санал дүгнэлтээ хараат бусаар гарган ажилласан.
- Их хэмжээний хэлцэл Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулагдаагүй. Сонирхлын зөрчилтэй 1 хэлцэл хийх асуудал хэлэлцэн санал өгсөн.

Тайлан бичсэн:  М.Батжаргал /ТУЗ-ийн хараат бус гишүүн/